

## Ипотекийн зээлийн тайлан

2016 оны 6 дугаар сар

Банкууд 2016 оны 6 дугаар сард нийт 2397 зээлдэгчид 138.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3799.4 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 84906-д хүрчээ. Тайлант сард 5%-ийн хүүтэй 44.1 тэрбум төгрөгийн зээлийг 966 зээлдэгчдэд олгосон бол 8%-5% руу 179 зээлдэгчдийн 7.7 тэрбум төгрөгийн зээлийг шилжүүлжээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 0.6 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 11.8 нэгж хувиар буурч 19.0 хувьд хүрсэн байна.




Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.1 хувь буюу 2929.4 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5 болон 8 хувийн хүүтэй зээл, 5 болон 8 хувийн

хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 21.3 хувь буюу 808.4 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.6 хувь буюу 61.6 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2016 оны 6 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.1 хувь нь төгрөгийн, 0.9 хувь нь валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 6 дугаар сарын байдлаар 2.1 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1 байна.



### Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 35.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар тус тус өссөн байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 90.6 хувь буюу 125.0 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 9.4 хувь буюу 12.9 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 6 дугаар сарын байдлаар 57.6 сая төгрөг байна.

Тухайн сард 42.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсчээ.




### Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 2397 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 2106 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 291 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2016 оны 6 дугаар сарын байдлаар нийт 84906 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас

62080 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 2163 нь 5 хувийн хүүтэй зээлд, 1029 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 20956 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1870 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




### Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3.0 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 19.1 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 6 дугаар сарын байдлаар 16.2 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 43.0 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Харин нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 1.1 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Ипотекийн зээл, хугацааны ангиллаар



### Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 6 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 7.7 хувь болжээ. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 8.9 нэгж хувиар буурсан байна.

Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.3 хувь байв.

## Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:		Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:	
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)			ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй	
2008	12	217,977.5			8.4	16,522		
2009	12	226,040.6			8.6	16,784		
2010	12	333,776.6			9.6	16,700		
2011	12	669,662.8			12.9	26,869		
2012	12	845,204.4			13.0	29,887		
2013	12	1,938,945.3	1,248,633.8		16.1	48,320	30,600	
2014	1	2,021,424.9	1,324,898.9		16.2	49,731	32,190	
	2	2,121,802.6	1,382,084.1		16.1	53,611	33,346	
	3	2,193,368.6	1,451,938.1		15.9	54,787	34,632	
	4	2,280,503.5	1,538,506.8		16.0	56,137	36,081	
	5	2,365,349.5	1,618,127.2		15.8	57,579	37,488	
	6	2,440,007.1	1,684,583.9		15.2	58,793	38,659	
	7	2,492,105.2	1,728,222.8		15.7	59,756	39,507	
	8	2,553,827.2	1,780,078.3		15.6	60,851	40,405	
	9	2,619,161.1	1,833,494.0		15.5	62,017	41,390	
	10	2,703,792.6	1,903,636.6		15.8	63,652	42,772	
	11	2,762,726.8	1,954,341.3		16.2	64,577	43,621	
	12	2,844,706.3	2,027,952.9		16.7	66,334	45,283	
2015	1	2,898,731.0	2,072,894.5		16.3	67,233	46,134	
	2	2,949,116.5	2,121,339.7		16.6	68,126	47,108	
	3	3,015,535.1	2,196,795.5		16.5	69,269	48,512	
	4	3,082,551.7	2,263,794.5		16.6	70,498	49,691	
	5	3,128,182.4	2,305,308.1		16.4	71,355	50,462	
	6	3,192,029.1	2,363,999.7		16.4	72,412	51,438	
	7	3,230,507.8	2,400,625.2		16.1	73,208	52,181	
	8	3,267,175.5	2,433,968.6		16.3	73,949	52,858	
	9	3,319,711.8	2,481,556.8		16.2	74,848	53,643	
	10	3,370,510.2	2,534,505.4		16.8	75,877	54,612	
	11	3,412,929.6	2,570,150.9		16.4	76,583	55,295	
	12	3,432,957.6	2,590,987.6		16.7	77,105	55,830	
2016	1	3,434,849.9	2,595,234.1		16.3	77,226	56,031	
	2	3,459,596.6	2,623,837.0		16.6	77,673	56,577	
	3	3,565,321.5	2,679,829.3		17.1	81,015	57,659	
	4	3,632,982.1	2,751,292.4		16.1	82,320	59,001	
	5	3,704,168.2	2,832,261.7		16.2	83,280	60,455	
	6	3,799,389.7	2,929,375.2		16.4	84,906	62,080	

## Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 6 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа (жилтээр)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилтээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,912,350.0	76.7%	2,226,072.2	76.0%	250.2	8.6	57407	43,252
2 Дархан-Уул	123,980.4	3.3%	110,820.3	3.8%	229.2	6.3	3611	3,071
3 Орхон	122,116.9	3.2%	107,523.7	3.7%	185.7	5.8	3140	2,649
4 Дорноговь	77,650.6	2.0%	64,264.7	2.2%	197.4	6.5	2246	1,753
5 Дорнод	56,573.7	1.5%	51,550.2	1.8%	224.9	5.7	1801	1,544
6 Увс	49,802.0	1.3%	36,287.5	1.2%	226.2	7.3	1620	869
7 Сэлэнгэ	49,691.0	1.3%	37,963.2	1.3%	160.5	7.2	1697	1,135
8 Өвөрхангай	47,016.6	1.2%	33,836.3	1.2%	199.8	7.6	1654	881
9 Өмнөговь	43,776.4	1.2%	33,881.0	1.2%	195.5	8.6	1216	846
10 Ховд	43,674.7	1.1%	35,982.2	1.2%	215.9	6.1	1393	1,014
11 Баянхонгор	32,938.5	0.9%	27,171.3	0.9%	204.6	5.2	1010	734
12 Сүхбаатар	30,811.0	0.8%	22,427.1	0.8%	209.1	7.6	1020	613
13 Архангай	29,038.6	0.8%	22,533.1	0.8%	157.7	7.0	841	549
14 Баян-Өлгий	25,518.3	0.7%	13,914.4	0.5%	171.8	7.3	1163	376
15 Говь-Алтай	22,576.7	0.6%	17,951.2	0.6%	182.5	5.8	733	508
16 Завхан	22,268.4	0.6%	13,511.4	0.5%	143.4	9.6	797	338
17 Хөвсгөл	22,190.2	0.6%	11,455.2	0.4%	197.0	6.0	867	265
18 Хэнтий	21,608.2	0.6%	17,376.5	0.6%	165.9	5.8	640	468
19 Төв	19,146.7	0.5%	12,105.5	0.4%	171.7	6.0	429	271
20 Дундговь	17,659.2	0.5%	12,938.1	0.4%	155.4	6.4	581	370
21 Булган	14,983.0	0.4%	7,647.5	0.3%	193.9	7.5	526	197
22 Говьсүмбэр	14,018.6	0.4%	12,162.8	0.4%	209.3	5.8	514	377
<b>Нийт</b>	<b>3,799,389.7</b>	<b>100.0%</b>	<b>2,929,375.2</b>	<b>100.0%</b>	<b>229.1</b>	<b>7.7</b>	<b>84906</b>	<b>62080</b>

2016 оны 6 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.7 хувийг Улаанбаатар хотод, 23.3 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.0 хувь буюу 124.0 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 13.8 хувь буюу 122.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.8 хувь буюу 77.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.